

**“МОН-ИТ БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2020 оны 04 сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 14:00 цагт ХУД-ийн 2-р хороо Арьс ширний үйлдвэрийн хашаанд байрлах өөрийн байранд хуралдлаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг Өнөөдөр сонин болон Өдрийн сонины 2020 оны 03 сарын 16-ний өдрийн болон 2020 оны 03 сарын 31-ний өдрийн дугаарт тус тус нийтлүүлэн хувьцаа эзэмшигчдэд хүргэв. Хурлыг Хувьцаа эзэмшигч Б.Анхболд даргалав.

Хурлыг эхлүүлэхээр хурлын тооллогын комиссын дарга П.Азжаргал ирцийн мэдээг танилцуулна.

Тооллогын комисс: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. “Мон-Ит Булигаар” ХК-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн мэдээг мэдээллээ. 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн ээлжит хуралд компанийн нийт 400212 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг төлөөлж 352627 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаа, нийт хувьцааны 88.1 хувийн хувьцаа эзэмшигч нар хүрэлцэн ирсэн байна. Иймд компанийн хуулийн 69-р зүйлийн 69.1-д зааснаар хурлын ирц бүрдэж байгаа учир хурал хүчин төгөлдөр нээж байгааг мэдэгдэе.

А.Энхмэнд: Сайн байцгаана уу. Хүндэт хувьцаа эзэмшигчиддээ энэ өдрийн мэнд хүргэе. Бид “Мон-Ит Булигаар” ХК-ны хяналтын багцыг худалдан авч Монголын арьс ширний салбарын хамгийн анхны бөгөөд томоохон үйлдвэрлэгч компанийн үйл ажиллагааг сэргээн босгох ажлыг эхлүүлээд 9 сар болжээ. Иймд энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж та бүхэнд өөрсдийн ажлыг танилцуулан хэлэлцэхдээ таатай байна. Бидний үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүйг ХЭХ-ийн материалаас уншиж танилцах боломжтой.

За ингээд товчоор голлох санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд болон ТУЗ-ийн дүгнэлтийг та бүхэнд танилцуулая.

Та бүхэн presentation-рүү анхаарлаа хандуулна уу.

А.Энхмэнд: За ингээд Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя.

Нэгдүгээрт: “Мон-Ит Булигаар” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.

Хоёрдугаарт: “Мон-Ит Булигаар” ХК-ны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг /кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн/-ийг 1 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн сонгох.

Б.Анхболд. За сайн байцгаана уу. Манай “Мон-Ит Булигаар” ХК нь 2019 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн Хувьцаа Эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн Удирдах

зөвлөлийг шинээр томилж, ТУЗ байгуулагдсанаас хойш 5 сарын хугацаанд үйлдвэрийн барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмж болон хүний нөөцийн менежментийн шинэчлэлд нийтдээ 1,4 тэрбум төгрөгийн томоохон хөрөнгө оруулалт хийсэн байна.

Б.Анхболд: За баярлалаа. Эргээд хэлэлцэх асуудалдаа ороё. “Мон-Ит Булигаар” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг танилцуулъя.

Мөн ТУЗ-ийн гишүүдийг /кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн/-ийг 1 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн сонгох уу. Та бүхэн тарааж өгсөн ХЭХ-ийн материалын 20-27 дугаар хуудаснаас харж болно.

- За бүгд дэмжлээ.

А.Энхмэнд: Баярлалаа. Та бүхэнд тараасан материалын хамгийн сүүлийн хуудсан дээр санал авах хуудас байгаа. Та бүхэн материалтайгаа дахин нэг сайн танилцаад санал авах хуудсаа бөглөж өгөх байгаа. Саналын хуудас бөглөх зааврыг манай тооллогын комиссоос танилцуулнаа.

Тооллогын комисс: За компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох асуудлыг санал хураах кумулятив аргаар явуулах байгаа. Кумулятив арга гэдэг нь танд байгаа нийт хувьцааны тоог нэр дэвшигчдийн нийт тоогоор үржүүлэн тооцсоноор таны санал өгөх нийт эрхийн тоо гардаг байгаа. Та бүхэнд санал хураах асуудлаар ойлгомжгүй зүйл, асуух асуулт байвал асууж болно шүү.

А.Энхмэнд: За саналаа өгсөн та бүхэнд баярлалаа. Одоо манай тооллогын комиссоос санал хураалтын дүнг хурааж танилцуулна.

Тооллогын комисс: “Мон-Ит Булигаар” ХК-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал асуулгын дүн нэгтгэгдэн гарсан байна. Хуралд оролцогч нийт хувьцаа эзэмшигчдийн 88,1 хувийн саналаар 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн баталсан байна. Мөн дараагийн асуудал ТУЗ-ийн гишүүдийг /кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн/-ийг 1 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн улируулан 88.1 хувийн саналаар сонгогдсоныг тус тус хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан батлуулсугай.

Б.Анхболд: За баяр хүргэе. Өнөөдрийн манай хувьцаа эзэмшигчдийн хурал хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууслаа. Хуралд хүрэлцэн ирж оролцсон та бүхэнд маш их баярлалаа. ТУЗ-ийн цаашдын ажилд амжилт хүсэе.

Хувьцаа эзэмшигчдийн хурал 15 нэг 30 минутанд дуусав.

Танилцсан: Хурлын дарга

Б.Анхболд

Тэмдэглэл хөтөлсөн: Нарийн бичиг

Б.Баянжаргал

